



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Ховд

Хөрөнгө оруулалтын ашиглалтыг
сайжруулах тухай

“Аймаг, сумдын 2017 оны Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитын дүнгийн тухай” аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатарын мэдээллийг хэлэлцээд өссөн дүнгээр /2011-2017 он/ аймаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн аудитаар нийт 2800.1 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 640.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 565.2 сая төгрөгийн албан шаардлага, 1594.4 сая төгрөгийн зөвлөмж, сум хөгжүүлэх сангийн аудитаар нийт 3981.3 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 269.2 сая төгрөгийн акт, 3712.1 сая төгрөгийн зөвлөмж буюу аудитын нийт дүнгээр (өмнөх оны албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой) 6781.4 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 909.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 565.2 сая төгрөгийн албан шаардлага, 5306.5 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж бичигдсэнийг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймаг дахь Төрийн аудитын газраас “Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүнд”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн дүгнэлтийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Г.Пүрэвганди/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

1.1. Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангаар хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг эрс сайжруулан биелэлтийн явц, үр дүнд тавих хяналтыг тогтмолжуулж хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх

3.2.Иргэдээс санал авч хэлэлцэн зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, зохих зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэснээр худалдан авах ажиллагааг олон нийтэд ил тод зарлан зохион байгуулж хэрэгжүүлэх.

3.3.Сумын Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн талаар хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд баталсан журмын биелэлт, байгуулсан ажлын хэсгийн чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч үр дүнг тооцож ажиллах.

Дөрөв. Тус тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/, аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор /Х.Болдбаатар/ нарт тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 02

Ховд

Хуваарь баталж зөвшөөрөл
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2, 22 дугаар зүйлийг 22.2, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.33, Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалт, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/515 дугаар тушаал, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тоо толгойг сийрүүлэх, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор барих загас болон агнах заарт хархны хуваарийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Тоо толгойг сийрүүлж, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор барих загасны байгалийн нөөц ашигласны төлбөр /килограмм тутамд/-ийн дээд хязгаарыг 80 хувиар хөнгөлж, ан амьтан барих агнах зөвшөөрлийн хураамжийг тухайн амьтны экологи эдийн засгийн үнэлгээний дээд хязгаараар буюу 4 хувиар тооцохыг зөвшөөрсүгэй.


3.Тухайн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар заарт харх агнахад төлбөрийн доод хязгаарыг 80 хувиар хөнгөлж, ан амьтныг барих агнах зөвшөөрлийн хураамжийг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний доод хязгаараар буюу 2 хувиар тооцохыг зөвшөөрсүгэй.

4.Батлагдсан хуваарийн дагуу мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж, 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 20-ны хооронд зохион байгуулж, төлбөр хураамжийг төсөвт төвлөрүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хар-Ус нуур орчмын тусгай хамгаалалттай газар

нутгийн хамгаалалтын захиргааны дарга /С.Батмөнх/, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Л.Батбаяр/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /П.Эрдэнэчулуун/, Дөргөн, Мянгад, Чандмань сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019
оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02
дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



СҮРГИЙН БҮТЦИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗОРИЛГООР БАРИХ, АГНАХ
АМЬТНЫ ХУВААРЬ

№	Сумын нэр	Байршил	Загасны хэмжээ /ширхэг/	Заарт хархны хэмжээ / ширхэг/
1	Мянгад	Хар-Ус нуур	5 000	10 000
2	Дөргөн	Хар-Ус нуур	5 000	10 000
3	Чандмань	Хар-Ус нуур орчим	-	10 000
	Нийт		10 000	30 000

-----oOo-----



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 03

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Г.Пүрэвганди/-д, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг шуурхай зохион байгуулан үр дүнг тооцож, улирал тутам Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 04

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

Монгол Улсын "Гавьяат багш"-аар

1. Нацаг Гэрэлхүү - Жаргалант сумын Хайрхан багийн өндөр настан

"Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-оор

1. Шагдар Батсүх - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч

2. Даржаа Баатарсүрэн - Алтай сумын Засаг даргын Тамгын газрын дарга

3. Зодов Лувсан - Жаргалант сумын иргэн

"Алтан гадас одон"-гоор

1. Дамдинсүрэн Цагаанцоож - Буянт сумын өндөр настан

2. Цогтбазар Цэцэгсүрэн - Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн багш

"Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар

1. Хавчиг Алтантуяа - Khovdnews.mn цахим сайтын сэтгүүлч

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 05

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Г.Пүрэвганди/-д, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг шуурхай зохион байгуулан үр дүнг тооцож, улирал тутам Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 06

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор

1. Чойсүрэн Батнасан - Дуут сумын Босго багийн өндөр настан

“Алтан гадас одон”-гоор

1. Баатар Отгонбаяр - Мөнххайрхан сумын Борт өндөр настан
2. Пагаа Самбуу - Мөнххайрхан сумын Алаг багийн малчин
3. Норжин Амаржаргал - Мөнххайрхан сумын Алаг багийн өндөр настан
4. Чойсүрэн Янжив - Мөнххайрхан сумын Алаг багийн өндөр настан
5. Бумбаа Янжмаа - Мөнххайрхан сумын Сэнхэр багийн өндөр настан
6. Цэрэн Энхжаргал - Ховд аймаг дахь Сум дундын Шүүхийн шүүгч
7. Елемес Хуантхан - Жаргалант сумын Цамбагарав багийн өндөр настан

8. Маутхан Оралбай - Ховд сумын Дунд ус багийн өндөр настан
9. Азваан Хашбаатар - Хар-Ус нуур орчмын УТХГН-ын
хамгаалалтын захиргааны мэргэжилтэн

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар

1. Сүх Баяндаа -Мөнххайрхан сумын Сэнхэр багийн
малчин
2. Самдан Мөнхтөр -Мөнххайрхан сумын Сэнхэр багийн
малчин

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 07

Ховд

Хөрөнгө шилжүүлэх санал уламжлах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8, 31 дүгээр зүйлийн 31.1,2,3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1.Ховд аймгийн "Ховд суврага" Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 1960 онд ашиглалтанд орсон нийт 13,759,700.00 төгрөг (арван гурван сая долоон зуун тавин есөн мянга долоон зуу)-ийн балансын үнэ, 13,530,371.00 төгрөг (арван гурван сая таван зуун гучин мянга гурван зуун далан нэг)-ийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Тагнуулын ерөнхий газрын Ховд аймаг дахь газарт балансаас балансад шилжүүлэх саналыг дэмжин Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжилсугай.

2. Хөрөнгө шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/, Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



Ховд аймгийн "Ховд суврага" Орон нутгийн өмчит үйлдвэрийн газраас Тагнуулын ерөнхий газрын
Ховд аймаг дахь газарт балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Үндсэн хөрөнгө шилжүүлж буй байгууллагын нэр	Үндсэн хөрөнгө хүлээн авч буй байгууллагын нэр
1	Сүмийн барилга	1690.01.01	ш	1	13,759,700	13,530,371	229,329	Ховд аймгийн Ховд суврага Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	Тагнуулын ерөнхий газрын Ховд аймаг дахь газарт
	НИЙТ ДҮН				13,759,700	13,530,371	229,329		



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 08

Ховд

Журмыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "в", 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Ховд хөшөөт хөгжил сан"-ийн журмыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Г.Пүрэвганди/, Засаг дарга /Б.Дүгэржав/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг шинэчлэн баталсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны "Журам батлах тухай" 59 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 09

Ховд

Тусламж олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3 дахь заалт, Жаргалант сумын иргэн Б.Энхтуяагийн өргөдөл, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд 38 жил тасралтгүй ажиллаж байсан өндөр настан Бямбажав овогтой Энхтуяад Япон улсын Ногая хотын Серэн эмнэлэгт 200.0 сая төгрөгийн өртөгтэйгөөр эмчилгээ хийлгэхэд дэмжлэг болгож 20.0 сая төгрөг /хорин сая/-ийн тусламж үзүүлсүгэй.

2. Б.Энхтуяад тусламжаар олгох 20.0 сая төгрөгийг аймгийн "Хөшөөт хөгжил сан"-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-т зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 10

Ховд

Аймгийн 2019 оны нэгдсэн арга
хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.7.1 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2019 онд зохион байгуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Нийтээр тэмдэглэх баяр, ойн арга хэмжээ, тэмдэглэлт өдрүүдийг салбар, байгууллагын хэмжээнд бүтээн байгуулалтын ажил өрнүүлж ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэх, сургалт, семинар, соёл урлаг, спортын болон бусад арга хэмжээнүүдийг төлөвлөсөн хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг сум, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж хэрэгжилтийн явцыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/, Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/ нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 02 сарын 27 өдрийн
10 дугаар тогтоолын хавсралт



АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2019.02.27

Ховд хот

Д/Д	Арга хэмжээний нэр	Хугацаа	Хариуцах байгууллага
1. Нийтээр тэмдэглэх баярын өдөр:			
1.1.	Шинэ жил	1 дүгээрсарын 1	Бүх нийтээр
1.2.	Цагаан сар, Хүннү гүрэн байгуулагдсаны ой	Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1-3	Бүх нийтээр
1.3.	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр	3 дугаар сарын 8	Бүх нийтээр
1.4.	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр	6 дугаар сарын 1	Бүх нийтээр
1.5.	Үндэсний их баяр наадам, Их Монгол улс байгуулагдсаны болон ардын хувьсгалын ой	7 дугаар сарын 11-15	Бүх нийтээр
1.6.	Монгол бахархлын өдөр, Их эзэн Чингис хааны өдөр	Өвлийн тэргүүн сарын шинийн нэгэн	Бүх нийтээр
1.7.	Бүгд найрамдах улс тунхагласан өдөр	11 дүгээр сарын 26	Бүх нийтээр
1.8.	Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр	12 дугаар сарын 29	Бүх нийтээр
2. Ойн арга хэмжээ:			
2.1.	Гал түймэр унтраах, аврах 48 дугаар анги байгуулагдсаны 50 жилийн ой	3 дугаар улиралд	Онцгой байдлын газар
2.2.	Манхан сумын соёлын төв үүсэн байгуулагдсаны 90 жилийн ой	7 дугаар сард	БСУГ, сумын Соёлын төв
2.3.	Ард Аюуш мэндэлсний 160 жилийн ой	7 дугаар сард	Цэцэг сумын ЗДТГ
2.4.	Зая бандид Намхайжамцын мэндэлсний 420 жилийн ой, даншиг наадам	7, 8 дугаар сард	Монгол улсын Засгийн газрын тогтоолоор
2.5.	Жаргалант сумын 3 дугаар сургууль үүсэн байгуулагдсаны 40 жилийн ой	8 дугаар сард	БСУГ, 3-р сургууль
2.6.	Мэс заслын алба үүсэн байгуулагдсаны 90 жилийн ой	8 дугаар сард	ЭМГ, БОЭТ
2.7.	Мөст сумын соёлын төв үүсэн байгуулагдсаны 70 жилийн ой	8 дугаар сард	БСУГ, сумын Соёлын төв
2.8.	Баруун бүсийн бурхан шашны төв Ганданпунцагчойлон хийд үүсэн	8 дугаар сард	БСУГ, ОНӨГ, Ховд суварга

	байгуулагдсаны 10 жилийн ой, Ховд аймгийн хөгжлийн төлөө сангийн ой		ОНӨААТҮГ
2.9.	Дөргөн сумын цэцэрлэг үүсэн байгуулагдсаны 40 жилийн ой	9 дүгээр сард	БСУГ, Дөргөн сумын цэцэрлэг
2.10.	Ховд их сургууль үүсэн байгуулагдсаны 40 жилийн ой	9 дүгээр сарын 19-21	Ховд Их сургууль
2.11.	Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ой	9 дүгээр сард	БСУГ, 3 дугаар цэцэрлэг
2.12.	Атар газар эзэмшсэний 60 жилийн ой	9 дүгээр сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар
2.13.	Өрхийн эрүүл мэндийн төвүүд үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой	9 дүгээр сард	ЭМГ, БОЭТ, Өрхийн эмнэлгүүд
3. Нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр:			
3.1.	Монгол улсын үндсэн хуулийн өдөр	1 дүгээрсарын 13	Аймгийн ИТХ, ЗДТГ
3.2.	Эх орончдын өдөр	3 дугаарсарын 1	Аймгийн ИТХ, ЗДТГ, улс төрийн намууд
3.3.	Монгол цэргийн өдөр	3 дугаар сарын 18	Цэргийн штаб
3.4.	Монгол улсын төрийн далбааны өдөр	7 дугаар сарын 10	ЗДТГ, ТЗУХ
3.5.	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр	9 дүгээр сарын 10	Аймгийн ИТХ, ЗДТГ
3.6.	Ахмадын өдөр	10 дугаар сарын 1	Ахмадын хороо
3.7.	Ардчилал, хүний эрхийн өдөр, Монгол улсад анхны улс төрийн жагсаал хийсэн өдөр	12 сарын 7-10	Аймгийн ИТХ, ЗДТГ, Улс төрийн намууд, ХоИС
4. Тэмдэглэлт өдрүүд:			
4.1.	Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор	1-12 сарыг дуустал	Холбогдох байгууллагууд
4.2.	Наурызын баяр	3 дугаар сарын 22	Аймгийн ИТХ, ЗДТГ
5. Соёл урлаг, спортын арга хэмжээ:			
5.1.	"Цодгор хүү- 2019" тэмцээн	1 дүгээр сарын 05	ГБХЗХГ, БТСГ
5.2.	Цагаан сарын үндэсний бөхийн барилдаан	2 дугаар сар	Аймгийн ЗДТГ, БТСГ, ҮБХ
5.3.	Хүчний байгууллагуудын олон төрөлт тэмцээн	3 дугаар сард	Аймгийн Шүүх
5.4.	Волейболын идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээн	4 дүгээр сарын 2-9 -ний өдрүүдэд	Аймгийн ЗДТГ, БТСГ
5.5.	"Уран жиргээ-2019" уран уншлагын наадам	3 дугаар сард	ГБХЗХГ
5.6.	Олон улсын харилцаа дууны "Ховд Айтыс-2019" наадам	3 дугаар сарын 17-18	ЗДТГ, БСУГ, ХДТ, Ховд аймгийн Ел Береке ТББ

5.7.	Жудо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн	4 дүгээр сард	БТСГазар
5.8.	"Хүүхдийн ертөнц-2019" гар зургийн уралдаан	4 дүгээр сард	ГБХЗХГ
5.9.	Хөл бөмбөгийн олон хотын нээлттэй тэмцээн	6 дугаар сард	БТСГ, Хөл бөмбөгийн холбоо
5.10.	Эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдийн урлагийн анхдугаар наадам	6 дугаар сард	ЗДТГ, ЭМГ
5.11.	Үндэсний сурын улсын аварга шалгаруулах тэмцээн	7 дугаар сард	БТСГ, Сурын холбоо
5.12.	Олон үндэстэн, ястан залуучуудын урлаг спортын фестиваль наадам	8 дугаар сарын 1	Аймгийн ЗДТГ, БТСГ
5.13.	Олон хотын ширээний теннисний тэмцээн	8 дугаар сард	Монголын ширээний теннисний холбоо
5.14.	Жангар-2 наадам	8 дугаар сард	Булган сумын ИТХ, ЗДТГ
5.15.	Баруун бүсийн утга зохиолын чуулган	9 дүгээр сарын сүүлийн хагаст	ЗДТГ, Монголын зохиолчдын эвлэлийн "Алтай" нэгдэл
5.16.	Цэцэг сумын соёлын өдрүүд	9 дүгээр сарын 19	Сумын ЗДТГ
5.17.	Үенч сумын соёлын өдрүүд	9 дүгээр сарын 20	Сумын ЗДТГ
5.18.	Мянгад сумын соёлын өдрүүд	9 дүгээр сарын 21	Сумын ЗДТГ
5.19.	Алтай сумын соёлын өдрүүд	9 дүгээр сарын 23	Сумын ЗДТГ
5.20.	Зэрэг сумын соёлын өдрүүд	9 дүгээр сарын 24	Сумын ЗДТГ
5.21.	Чандмань сумын соёлын өдрүүд	9 дүгээр сарын 29	Сумын ЗДТГ
5.22.	Жаргалант сумын соёлын өдрүүд	10 дугаар сарын эхний 7 хоногт	Сумын ЗДТГ
5.23.	Амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулах ёслолын арга хэмжээ	12 дугаар сард	ЗДТГ, БТСГ
5.24.	Аймгийн хүүхдийн нэгдсэн "Харш"-ийн сүлд модны наадам	12 дугаар сар	ГБХЗХГ
6. Сургалт, семинар, үүлзалт, зөвлөгөөн:			
6.1.	Аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн	1 дүгээр сарын 28, 29	Аймгийн ЗДТГ
6.2.	2, 3, 4 дэх жилдээ ажиллаж байгаа багш нарын сургалт	1 дүгээр сарын 07-11	БСУГ
6.3.	Барилгын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн сургалт, өдөрлөг	2, 3 дугаар сард	Аймгийн ЗДТГ
6.4.	Хүнс, хөдөө аж ахуйн удирдах ажилтнуудын сургалт семинар	3 дугаар сард	ЗДТГ ХХААГ
6.5.	Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөн	3 дугаар сард	ЗДТГ, ЭМГ
6.6.	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А/З сургалт	3 дугаар сард	ОНӨГ

6.7.	Сумдын ахмадын байгууллагын удирдах ажилтнуудын зөвлөгөөн	3 дугаар сард	Аймгийн ЗДТГ, Ахмадын хороо
6.8.	Сумдын байгаль орчин, мал эмнэлэг, үржлийн хяналтын улсын байцаагчдын нэгдсэн зөвлөгөөн	1 дүгээр улиралд	МХГ, ХХААГ, БОАЖГ
6.9.	"Эх, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулахад орон нутгийн удирдлагуудын оролцоо, дэмжлэг" аймгийн зөвлөгөөн	4 дүгээр сард	ЗДТГ, ЭМГ
6.10.	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилтны анхдугаар зөвлөгөөн	4 дүгээр сар	ЗДТГ, ЭМГ
6.11.	Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөн, сургалт	4 дүгээр сард	ЗДТГ, ХХААГ
6.12.	Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөн	5 дугаар сард	ЗДТГ, ХХААГ
6.13.	Аймгийн ерөнхий боловсролын сургууль, сумдын соёлын төвийн номын санчдын сургалт	5 дугаар сарын 1 дэх Ням гараг	ЗДТГ, Нийтийн номын сан
6.14.	Онол практикийн бага хурал	5 дугаар сард	Аймгийн Шүүх
6.15.	Малчдын аймгийн зөвлөгөөн, сургалт семинар	5 дугаар сарын сүүлч 6 дугаар сарын эхэн	ЗДТГ, ХХААГ
6.16.	Баруун бүсийн НӨУБ-н сонгуультаан, ажилтнуудын нэгдсэн зөвлөгөөн сургалт, спорт, урлагийн арга хэмжээ	6 дугаар сард	Аймгийн ИТХ, ЗДТГ
6.17.	Багш нарын бага хурал, нэгдсэн зөвлөгөөн	8 дугаар сарын 25	БСУГ
6.18.	Баруун бүсийн уламжлалт анагаах ухааны анхдугаар зөвлөгөөн	9 дүгээр сард	ЗДТГ, ЭМГ
6.19.	Хичээлийн шинэ жилийн нээлт	9 дүгээр сарын 1	БСУГ, сумдын ЗДТГ
6.20.	Үйлдвэрлэл, барилгын салбарын ажилчдын сургалт	9 дүгээр сард	НДХэлтэс
7. Бусад арга хэмжээ /судалгаа, аян, үзэсгэлэн/:			
7.1.	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг иргэд олон нийтэд сурталчлах	1, 2, 3 дугаар улиралд	Аймгийн ИТХ, ЗДТГ, сумдын ЗДТГ, албан байгууллагууд
7.2.	"Хаврын өнгө - 2019" үзэсгэлэн худалдаа	2 дугаар сард	ЗДТГ, ХХ, ХХААГ
7.3.	Намрын ногоон өдрүүд, ургацын баяр, шилмэл малын үзэсгэлэн худалдаа	8, 9 дүгээр сард	ЗДТГ, ХХААГ
7.4.	"Цайны зам" өв соёлын наадам	9 дүгээр сарын 25-28	БОАЖГ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 11

Ховд

“Эвийн хүч” орон нутгийн өмчийн оролцоотой
аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 77.4 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Эвийн хүч” орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулсугай.

2.“Эвийн хүч” орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн сан болох 4.678.000.000 төгрөг /дөрвөн тэрбум зургаан зуун далан найман сая/-ийн хөрөнгийн 3.663.000.000 төгрөг буюу 78 хувийг орон нутгийн өмчид, 1.015.000.000 төгрөг буюу 22 хувийг “Ховд эвийн хүч” хоршооны өмчид байхаар тогтоосугай.

3.“Эвийн хүч” ОНӨОААТҮГ ын дүрмийг хавсралтаар баталсугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулж дүрэм батлах тухай” 132 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тус ОНӨОААТҮГ-ын дүрмийн санд хөрөнгө оруулсан “Ховд-Эвийн хүч” хоршоотой хамтран ажиллах тогтвортой байдлын гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д даалгасугай.

6.Үйлдвэрийн газрын даргыг томилж үйл ажиллагааг нь эхлүүлэх, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

